

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх заалт, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалт, 81 дүгээр зүйлийн 81.5.1, 81.5.2, 81.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

СОНГОН ШАЛГАРУУЛАХ ГИШҮҮНИЙ ТОО: 3

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага:

1. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах үр чадвар, мэдлэг боловсролтой байх;
 - **Боловсрол:** Магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй;
 - **Мэргэшил:** Банк, санхүү удирдлага, эрх зүйн чиглэлээр болон мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, хуульчаар 10-аас дээш жил ажилласан, үүнээс 5-аас доошгүй жилд эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай.
2. Нэр дэвшигч өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;
3. Компанийн хяналтын багц эзэмшигч хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд биш;
4. Нэр дэвшигч өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчийн эрх бүхий албан тушаалтан биш;
5. Компанийн өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш;
6. Өмнө нь дампуурсан компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаагүй;
7. Өмнө нь аль нэг компанийн ТУЗ-ийн гишүүн байх үедээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон бол түүнээс хойш 3-аас доошгүй жил өнгөрсөн;
8. Компанитай бизнесийн аливаа холбоогүй (Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хамтран ажиллах, зөвлөх үйлчилгээ, ажил үйлчилгээ үзүүлэх, худалдан авах зэрэг аливаа гэрээ хэлцэл хэлцлийг компанитай хийж байгаагүй);
9. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
10. Тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх;
11. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан, компанийн засаглалын гэрчилгээтэй байх;

Бүрдүүлэх материал:

1. Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт (хараат бус гишүүний шаардлага хангаж буй баталгаа)
2. Нэр дэвшигчийн товч танилцуулга буюу CV (төрийн албан хаагчийн анкет бөглөн ирүүлж болно);
3. Иргэний үнэмлэхийн хуулбар (сүүлийн 1 сарын дотор emongolia-с авсан иргэний үнэмлэхийн лавлагаа байж болно);
4. Боловсролын диплом, мэргэшсэн байдлын талаар гэрчилгээ, сертификатын хуулбар;
5. Компанийн засаглалын гэрчилгээний хуулбар;
6. Хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тодорхойлолт лавлагаа (сүүлийн 1 сарын дотор emongolia-с авсан байх);
7. Татварын өр төлбөргүй тодорхойлолт (сүүлийн 1 сарын дотор emongolia-с авсан байх);
8. Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (сүүлийн 1 сарын дотор emongolia-с авсан байх);
9. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт (сүүлийн 1 сарын дотор emongolia-с авсан байх);
10. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (сүүлийн 1 сарын дотор emongolia-с авсан байх)

Анхаарах зүйлс:

1. Хугацаа хоцорсон, материалын бүрдэл дутуу материалыг хүлээн авахаас татгалзаж, шалгаруулалтаас хасна.
2. Нэр дэвшигчийн ирүүлсэн материалыг зөвхөн сонгон шалгаруулалтын зорилгоор ашиглах бөгөөд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган 5 жилийн хугацаанд хадгална.
3. Сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчтэй холбогдон, ярилцлагын шатанд оролцох мэдэгдэлийг хүргүүлэх болно.

Материал хүлээн авах хугацаа:

Нэр дэвшигчийн материалыг 2026 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 18:00 цаг хүртэл boardsecretary@ardcredit.com хаягаар хүлээн авна.